



URGENT ТӨСЛИЙН
ХОВД ИХ СУРГУУЛЬ ДАХЬ
НЭГЖИД

ХОВД ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБА

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг
Утас: 99435750, 99438181

2022.09.16 № 23
танай _____ -ны № _____ -т

Хичээлийн хөтөлбөрийн санал
хүргүүлэх тухай

URGENT төслийн хүрээнд Ховд Их Сургууль дээр шинээр боловсруулж буй "Хотын экологи" цахим хичээлийн хөтөлбөрт Ховд хотын захирагчийн ажлын албаны хотын асуудал хариуцсан төрийн байгууллагын хувьд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хичээлийн тодорхойлолттой танилцаж үзэхэд хичээлийн нэр, зорилго, зорилт болон агуулга нь нийцсэн гэж үзэж байна.
2. Тус хичээлийн төрлийн хувьд мэргэжлийн сонгон судлах хичээлд оруулж буйг дэмжиж байна.
3. Тогтвортой хөгжлийн зорилт, ногоон хөгжлийг дэмжин ажиллах мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд энэ хичээл ач холбогдолтой гэж үзэж байна. Тус хичээлийн хүрээнд байгаль орчны чиглэлээр суралцаж буй магистрант, судлаачдад хотын экологийн асуудлуудыг системийн хүрээнд судлахаас гадна хотын хөгжлийн төлөвлөгөөнд экологийн талаас судалгаа хийх, төслийн санал боловсруулах чадвар олгохоор зорьж байгаа нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
4. Төрийн байгууллага, ажил олгогчийн хувьд бидний хүний нөөцийг чадварлаг боловсон хүчинээр бүрдүүлэх, тэдгээрийн чадавхийг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий бидний хүсэл шаардлагад нийцсэн хичээлийн хөтөлбөр байна.

ДАРГА /  Т.ГОНЧИГСҮРЭН